



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1364

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН  
С.МӨНХЧУЛУУН ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Самданьямын Мөнхчулууны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**


Иргэн Самданьямын Мөнхчулууны нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Самданямын Мөнхчулууны мөрийн хөтөлбөр / 3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН 12 ДУГААР ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР  
ДЭВШИГЧ**

**САМДАННЯМЫН МӨНХЧУЛУУНЫ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Улаанбаатар хот  
2020 он



## ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч нийт хүн амын 45% нь амьдарч байна. Хүн амын хэт төвлөрлөөс үүдэн агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл, нийтийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон асуудлууд тулгараад байна.

Хотын хүн амын амьдралыг зохицуулсан, иргэд оршин суугчиддаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх хотын дүрэм, стандартыг бий болгож, тулгамдсан асуудлаа өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

**ЗОРИЛТ:** Хотыг нэгдсэн стандарттай болгож, иргэдийн сурч хөдөлмөрлөх, бизнес эрхлэх, аюулгүй орчинд амьдрах, зорчих аятай таатай нөхцөлийг бий болгоно.

- Хотыг нэгдсэн дүрэм, стандарттай болгож, иргэдийн оролцоотой, иргэн төвтэй хот болох нөхцлийг бүрдүүлнэ.
- Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэр, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулна.
- Гарааны бизнес эрхлэгчидэд бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох мэдлэг олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэхийг дэмжиж ажиллана.
- Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллана.
- Сургуулийн насны хүн амын тооны өсөлтөнд тулгуурлан бүх шатны сургалтын байгууллагын дэд бүтэцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчин бий болгож чанартай үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- Сургуулийн өмнөх боловсрол, бага сургууль нь хүүхдийн төлөвшил хөгжлийн суурь үе хэмээн үзэж хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг дэмжинэ.





- Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцвэржүүлж, хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг дэмжих бодлого санаачилна.
- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжиж, түлхүү анхаарч ажиллана.
- Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, ижил түвшинд хүргэхийг зорьж ажиллана.
- Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрт хүрэх нийгмийн бодлого, зорилтот бүлэгт үзүүлэх халамж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- Гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төлөвлөсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгох ажлыг дэмжинэ.
- Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах ажлыг дэмжинэ.
- Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.
- Гэр хорооллын болон орон сууцны хороолол дундах зам, гэрэлтүүлэг, тохижилт бүхий талбайг засварлаж, нэмэгдүүлж, нэгдсэн стандарттай болгох ажлыг дэмжинэ
- Орчин үеийн жишигт нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх замаар түгжрэлийг бууруулах ажлыг дэмжинэ
- Нийслэлийн авто замуудын ус зайлуулах шугамыг засч сайжруулах, шинээр нэмэгдүүлэх ажлыг дэмжинэ.
- Хуучин орон сууцны байрнуудын гадна пасадыг дулаалах замаар дулаан алдалтыг бууруулж, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, хотын өнгө төрхийг сайжруулах ажлыг дэмжинэ.
- Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчныг бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж мөрдүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

...../Гарын үсэг/

САМДАННЯМЫН МӨНХЧУЛУУН

